



ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 99019602

И-мэйл: Tsaranchimeg@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 6-р баг

Төрийн байгууллагуудын 2-р ордон

Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэтгэсэн тайланд ТӨВ-2017/27/СТА-ТЕЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2016 оны төсвийн санхүүгийн нэтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 05-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн ахлах аудитор Ц.Саранчимэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2016 оны төсвийн санхүүгийн нэтгэсэн тайланг 2017 оны 03 дугаар сарын 05-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 05-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 31-нд Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн Ерөнхийлөн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.”, мөн хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 29.1.1.төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар: а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга буюу ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Мөн хуулийн 14.3-д Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

Засаг дарга нь дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2016 оны төсвийн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга, санхүүгийн албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 9 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн системтэй танилцахад санхүүгийн тайланг Сангийн яамны е-тайлангийн нэгтгэлээр нэгтгэгдсэн санхүүгийн тайланг ирүүлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын төсвийн нэгтгэсэн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг тодоруулахад Дэлхийн банкны төслийн хүрээнд хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцсэн интернетэд суурилсан программ хангамжийг ашиглан “Санхүүгийн тайлангийн И- баланс” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах

ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг нь ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг засаг даргын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг е-тайлангийн бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сум 2016 оны төсвийн орлогыг 3 шатанд 162106.1 мянган төгрөгийн төсвийн эх үүсвэр бүрдүүлэхээр баталсанаас гүйцэтгэлээр 127636.3 мянган төгрөг буюу 21.3 хувиар тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 10600.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 7489.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж батлагдсан төлөвлөгөө 3110.4 мянган төгрөг буюу 29.3 хувиар тасарсан байна.

Аймагт төвлөрүүлэх татварын орлого 115001.1 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 97028.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөө 17973.0 мянган төгрөг буюу 15.6 хувиар тасарсан байна.

Орон нутагт төвлөрүүлэх татварын орлого 8 нэр төрлийн 36505.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 23118.6 мянган төгрөг төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөө 13386.4 мянган төгрөг буюу 36.7 хувиар тасарсан байна.

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Татварын төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
ААНОАТ	3500.0	5155.0	147.3
НӨТ	6500.0	1811.4	27.9
Агаарын бохирдол	600.0	523.2	87.2
<u>Улсын төсөвт төвлөрүүлэх дүн</u>	<u>10600.0</u>	<u>7489.6</u>	<u>70.7</u>
АТБӨЯХ-ийн татвар	7000.0	6077.2	86.8
Газрын төлбөр	15542.6	12125.9	78.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	1537.0	4749.3	309.0
Суутган-1	90637.9	73725.7	81.3
Ус ашигласны төлбөр	283.6	350.0	123.4

<u>Аймагт төвлөрүүлэх дүн</u>	<u>115001.1</u>	<u>97028.1</u>	<u>84.4</u>
Үйл ажиллагааны орлого	9000.0	6670.9	74.1
Суутган-2	4000.0	5209.6	130.2
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсаны татвар		100.0	
Бууны албан татвар	690.0	609.5	88.3
Улсын тэмдэгтийн хураамж	2200.0	1187.6	54.0
Ой мод ашигласны төлбөр	700.0	754.7	107.8
Малын татвар		651.5	
Хог хаягдлын хураамж	4320.0	4192.5	97.0
Нэр зааж ангилагдаагүй орлого	13095.0	2919.4	22.3
Хүү торгууль	2500.0	822.9	32.9
<u>Суманд төвлөрүүлэх орлого</u>	<u>36505.0</u>	<u>23118.6</u>	<u>63.3</u>
<u>3 шатны орлого нийт дүнгээрээ</u>	<u>162106.1</u>	<u>127636.3</u>	<u>78.7</u>

Сумын ИТХ-ын 2015.12.19-ний 06 тоот тогтоолоор Сүмбэр сумын НЕҮ нь 2016 онд төсөвт зардлын эх үүсвэрийг орон нутгийн татварын орлогоор 36505.0 мянган төгрөг, аймгийн санхүүгийн дэмжлэгээр 225612.5 мянган төгрөг авахаар батлагдсан байна. Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нийт 1030646.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2016.08.24-ны 01 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг 63475.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан.

Сумын ИТХ-ын 2016.11.24-ны 03 тоот тогтоолоор ЗДТГ-ын төсвийг 280980.3 мянган төгрөг, Сумын ИТХ-ын төсвийг 31550.7 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ 50413.5 мянган төгрөг , тусгай зориулалтын шилжүүлэг 991192.7 мянган төгрөг нийт 1354137.2 мянган төгрөг тодотгон баталсан.

Аймгийн Засаг даргын зарим төсөвт байгууллагын төсөвт зохицуулалт хийх тухай 2016.12.23-ны өдрийн А/719 тоот захирамжаар цэцэрлэг 232156.3 мянган төгрөгөөр төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан баталсан байна.

Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах сан оны эхний үлдэгдэл 6218.4 мянган төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсныг ЗДТГазрын нэмэлт данс руу төвлөрүүлж зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сан

Сүмбэр сумын ОНХСанд 2016 оны эхэнд 2300.5 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байж, аймгаас ОНХ-ийн сангийн санхүүжилтээр 48113.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 7 төсөл арга хэмжээг 63475.7 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр сумын ИТХ аар батлан төлөвлөснөөс гүйцэтгэлээр өмнөх оны шилжих үлдэгдлээс оруулж нийт 8 хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 48113.0 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 2300.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

ОНХ-ийн сангийн зарцуулалтын байдалд холбогдох тендерийн болон санхүүгийн баримтуудыг нэг бүрчлэн шалгаж үзэхэд Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАА-ны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу 2016 онд хийгдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг багуудийн иргэдийн саналыг авч эрэмбэлэн нэгтгэсэн жагсаалтыг үндэслэн 2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын ИТХ-ын тогтоолоор 2016 оны 8-р сард тодотгон баталж төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын явцад ОНХСангийн тайлан, гүйцэтгэл гаргахдаа сумын ИТХ-аар батлагдсан төлөвлөгөөг буруу тооцсоныг залруулан 50.4 сая төгрөгөөр тайлагнасныг 63.4 сая төгрөг болгон залруулав.

2016 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэнээс гадна ИТХ-аар батлагдаагүй интернэтийн төлбөрт 4137.8 мянган төгрөгийн зардал, өмнөх аудитаар хууль зөрчсөн үйлдэлд төлбөрийн акт тогтоосны тайлант онд ОНХСангаас гарган зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалт болон Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Орон нутгийн төсөл боловсруулах журмын 6-р зүйлийн 6.3.1, 6.3.2 дахь заалтанд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөхгүй байх гэсэн заалтыг зөрчиж төлөвлөсөн байна.

Өмнөх аудитаар тавигдсан төлбөрийн актын 470,0 мянган төгрөгийг ОНХСангаас төлж барагдуулсаныг мөн холбогдох албан тушаалтнуудаар хариуцуулан нөхөн төлүүлэх шаардлагатай байна.

Сум хөгжүүлэх сан

Тус сумын “Сум хөгжүүлэх сан”-гийн мөнгөн хөрөнгийн дансанд 2016 оны эхэнд 6457.9 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна. Тайланд онд зээлийн эргэн төлөлтөөр 3870.5 мянган төгрөг, хүүгийн орлогоор 6694.6 мянган төгрөг бүгд 10565.1 мянган төгрөгний орлого орсон байна.

Тайланд онд сангаас 1500.0 мянган төгрөгийн зээлийг 1 зээлдэгчид олгосон байна. Сангийн харилцах дансанд оны эцэст 233532.6 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Сан нь оны эхэнд 103 зээлдэгчээс 229208.5 мянган төгрөгний зээл, хүүгийн авлагатай 2016 онд нэмж 1500.0 мянган төгрөгний зээл олгож, зээлдэгч нарт 6694.5 мянган төгрөгний хүү ногдуулж, 3870.5 мянган төгрөгний зээл хүү төлүүлж, оны эцэст 233532.6 мянган төгрөгний 104 иргэний зээл, хүүгийн авлагатай байна.

Жилийн эцэст байгаа зээл, хүүгийн авлага 233532.6 мянган төгрөгний 83.2 хувьтай тэнцэх 91 зээлдэгчийн 194306.9 мянган төгрөгний зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.

Эм эргэлтийн сан, Эрүүл мэндийн төвийн тайлангуудыг хувийн аудитаар хийгдэж тайланг тусад нь хүргүүлсэн болно.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 10 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна .

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2016 оны төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2016 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 3 шатандаа 34469.8 мянган төгрөг буюу 21.3 хувиар тасалсан, мөн нэр төрлөөр тооцвол орон нутгийн орлого 8 нэр төрлөөс 6 нэр төрлийн орлого 36.7 хувиар тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийн давтан гаргахгүй байхад анхаарч орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэх талаар санаачлагатай ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.

2. Сум хөгжүүлэх сангийн жилийн эцэст байгаа зээл, хүүгийн авлага 233532.6 мянган төгрөгний үлдэгдэлээс 83.2 хувьтай тэнцэх 91 зээлдэгчийн 194306.9 мянган төгрөгний зээл хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 194306.9 мянган төгрөгийн Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлийг барагдуулах талаар зөвлөмж хүргүүллээ.

3. СХСангийн орлогыг 8145.5 мянган төгрөгөөр зарлагыг 10423.5 мянган төгрөгөөр тайлагсаныг харилцахын хуулгатай тохируулан орлого 3870.5 мянган төгрөг зарлага 6148.5 мянган төгрөг болгож орлого зарлагыг анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1-д нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 8550.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

4. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2015 онд тус сумын СХСанд ахуй үйчилгээний тоног төхөөрөмж 15740.0 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилтийг олгож, 2015.02.10-нд 33 нэр төрлийн 15740.0 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДОрлогч Ч.Уртнасан, нярав Ш.Түмэнжаргал, мэргэжилтэн Б.Баяраа нарт хүлээлгэн өгснийг иргэдэд гэрээгээр олгоогүй санхүүгийн тайланд хөрөнгөөр тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 15470.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага бичигдлээ.

5. Төрийн сан дансанд үлдэгдэлтэй аймгийн 90 жилийн ойн билетийн орлого 950.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Төсвийн тухай 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчин авлагыг барагдуулалгүй ажилласан байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 950.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах төлбөрийн акт бичигдлээ.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд

6. Аймгийн татварын хэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл, татварын мэдээнээс 250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-д санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийн давтан гаргахгүй байхад анхаарч Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрийн сангийн хуулгатай тохируулан мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус 250.0 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлтийг давтан шалгах, шилэн дансны мэдээллийг заасан хугацаанд байршуулсан талаарх асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Анхаарал татахуйц асуудлууд:

Тус сумын санхүүгийн ажилтнуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.11-д өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах гэсэн заалтыг дагуу ажлын байранд дахь сургалтыг эрчимжүүлэн туршлагатай нягтлан бодогчдоос суралцах боломж бололцоог бий болгоход анхаарч ажиллах хэрэгтэй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2016 төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 254266.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил, материаллаг бус 250.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба 8550.0 мянган төгрөгийн материаллаг алдааг залруулж зөрчлийг арилгах талаар зөвлөмж хүргүүлэв.

245716.7 мянган төгрөгийн материаллаг хэмжээний алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг түвшингээс хэтэрсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэлийн 83.2 хувь болох 194306.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, улс, орон нутгийн орлогын төлөвлөгөө 3 шатандаа нийт 34469.8 мянган төгрөг буюу 21.3 хувиар тасалсан нийт 228776.7 мянган төгрөгийн материаллаг хэмжээний алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг түвшингээс хэтэрсэн тул орлого, авлагын дансдын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв аймгийн Аудитын газраас 1 зөвлөмжийн хариуг ирүүлээгүй байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг дахин нягталж шалгахад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил дахин давтагдсан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан төсвийн байгууллагууд дараах санал дүгнэлт авсан байна.Үүнд:

- ✓ Засаг даргын тамгын газар “Зөрчилгүй”
- ✓ Иргэдийн төлөөлөгчдийн хурал “Зөрчилгүй”
- ✓ Ерөнхий боловсролын сургууль “Зөрчилгүй”
- ✓ Сургуулийн өмнөх боловсрол “Зөрчилгүй”
- ✓ Эрүүл мэндийн төв “Зөрчилгүй”
- ✓ Соёлын төв “Зөрчилгүй” дүгнэлттэй байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 12 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

